



АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 10 сарын 31 өдөр

Дугаар 90/257

Улаанбаатар хот

Буцалтгүй тусламж олгох
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.5 дахь хэсэг, 43 дугаар зүйлийн 43.2.2 дахь заалт, Эрчим хүчний салбарын 2021-2022 оны хамт /тариф/-ын хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн 3.2, Амгалан дулааны станцын Захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд 2021-2022 онд хэрэгжүүлэхээр байгуулсан Хамтын гэрээний 6.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Авто, хүнд машин механизмын хэсгийн Нарийн үнс зөөвөрлөх тусгай тоноглолтой хүнд даацын автомашины жолооч Жамганы Алтантулгын эцэг нь нас барж уй гашуу тохиолдсон тул 1,344,000 (Нэг сая гурван зуун дөчин дөрвөн мянга)-н төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосугай.

2. Ж.Алтантулгад 1,344,000 (Нэг сая гурван зуун дөчин дөрвөн мянга)-н төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгохыг Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч (Ө.Удвал)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс (Б.Ган-Очир)-т даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



М.МӨНХӨӨ